

Онгорсон дорвон жилд Баян-Олгий аймгийн товд 532 орх ходооноос орж ирээд суурьшсан бол, сумуудын товд нүүн шилжигсдийн тоо үүнээс хамаагүй илүү болсон гэнэ.

Энэ нь аймаг сумын товд эмнэлэг, боловсрол, газар омчлол, халамж зэрэг торийн үйлчилгээний ажлыг хүндрүүлдэг гол шалтгаан болохын хажуугаар голцуу ходооноос малаа орхин нүүж ирээд суурьшсан малчид хот газрын ажилгүй, ядуу иргэдийн эгнээг оргожүүлж байна. Ногоо талаар малчдын оволжоонд хуучин гурваас таван айл нэг дор хамтдаа байдаг байснаа одоо нас ахимаг малчинтай ганц нэгээхэн айл оволжоогоо сахин үлддэг болжээ. Олгий сумын арван хоёрдугаар багт сүүлийн хоёр жилд орж ирээд суурьшсан 29 орхийн талаар ходолморийн хэлтсээс судалгаа хийхэд бараг сум бүрээс 1-4 орх нүүж ирсэн, «Юуны учир энд нүүж ирээ вэ?» гэсэн асуултанд тэд хүүхдээ сургуульд суралцуулах, мэргэжлийнхээ дагуу ажил эрхлэх, мал зуданд нэрвэгдсэн, ероос мал маллах сонирхолгүй, худалдаа наймаа хийсэн ч хот газар амьдрах сонирхолтой гэх зэргээр хариулсан байна.

Нүүж ирэгсдийн дунд ажил орлогогүй болсон, овлийн идэш, түүлээ түүлшээр гачигдсан, архичин болсон нь ч цоонгуй байна.